

Монгол – Германы хөгжлийн хамтын ажиллагаа

Санхүү, эдийн засгийн дэд сайд
доктор. проф. Л. Энхтайван

1990 оноос хойш Монгол Улс зах зээлийн харилцаа, ардчиллыг хөгжүүлэхийн хамт дэлхийн бусад орнуудтай харилцахдаа нээлттэй бодлого явуулж ирсэн. Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, цаашдын эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавихад ХБНГУ бидэнд эхнээс нь түүштай дэмжиж тусалж ирсэн. ХБНГУ манай улсын Европ дахь гол түнш, хоёр талын тусламжийн хувьд Япон улсын дараа орох гол хандивлагч орон билээ.

ХБНГУ - ын зээл тусламжийн бодлого, түүний хандлагаас

ХБНГУ-ын Засгийн газраас хөгжиж буй орнуудад үзүүлж байгаа хөгжлийн тусламжийн асуудлыг Холбооны Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Яам (ЭЗХАХЯ) хариуцдаг. Засгийн газар хөгжлийн бодлогоо тухайн цаг үеийн байдалтай уялдуулж өөрчлөхийн хамт дэлхий дахинд тулгарч буй асуудлуудыг тухай бүр нь оновчтой шийдвэрлэхэд чиглүүлж ирсэн. Өнөөгийн хөгжлийн бодлогын гол зорилго нь:

- Дэлхий дахин дахь ядууралтай тэмцэх,
- Өөртөө туслах нөхцлийг бүрдүүлж өгөх,
- Тогтвортой хөгжил,
- Нийгмийн хөгжлийн хандлагыг даяаршлийн үйл явцтай уялдуулах,
- Энх тайвныг хамгаалах зэрэг асуудал юм.

Германы хөгжлийн тусламж анх 1956 онд 50 сая дойч марк (DM)-ийн сантай эхэлж байсан бол одоо жил тутам 5,5 миллиард DM буюу 2,75 миллиард еврогийн тусламжийг олгодог болжээ.

Бусад орнуудтай хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын асуудлыг сүүлийн үед бүс нутгийн түвшинд илүүтэй авч үзэх шинжтэй болж байна.

Хөгжлийн хамтын ажиллагаа нь техник туслалцаа, санхүүгийн хамтын ажиллагаа гэсэн үндсэн хоёр хэлбэрийн зэрэгцээ буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж гэх мэт олон үйл ажиллагааг хамардаг.

Олон улсын хөгжлийн үндсэн асуудлуудаас гадна төрөл бүрийн сургалт, давтан сургалт зохион байгуулах, сайн дурын мэргэжилтнүүдийг төслийн ажилд хамруулах, төрийн бус буюу олон нийтийн байгууллагууд болон сүм хийд, буяны байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах, байгалийн гамшигт нэрвэгдэгсэд болон дүрвэгсдэд хүнс, эм, дулаан хувцас олгох зэрэг ажлыг энх тайван, найрамдал, хүний эрх, бүс нутгийн хямрал, аюулгүй байдлын асуудлын хүрээнд зохион байгуулдаг.

ХБНГУ нь Олон Улсын Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD)- аас гаргасан 1999 оны статистикийн мэдээгээр жилд 5,5 млрд. ам. долларын хөгжлийн тусламжийг олгож буй бөгөөд тусламжийн хэмжээгээрээ Япон (15,3 млрд. ам. доллар), АНУ (9,1 млрд. ам. доллар), Франц (5,6 млрд. ам. доллар)-ын дараа 4 дүгээр байрыг эзэлж байна. Гэхдээ OECD-ын статистикийн мэдээнээс үзэхэд дээрхи дөрвөн орон 1990 оноос хойш сүүлийн 10 жилд хөгжлийн тусламжийнхаа хэмжээг дунджаар 50 орчим хувиар бууруулаад байгаа болно. OECD-ийн нийт 22 орон 1999 онд хөгжлийн тусламж (ODA)-д зориулж нийт 56,4 млрд. ам доллар зарцуулахаар төлөвлөсөн байна.

ХБНГУ байгуулагдсан 1949 оноос хойш анх удаа буюу 2000 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ХБНГУ-ын Засгийн газар хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны талаар Бундестагд Засгийн газрын мэдэгдлийг хийж, шинэ зууны хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны үндсэн чиглэл, зорилтыг тодорхойлсон болно.

ХБНГУ-ын Засгийн газар төсвөө хэмнэх, ЭЗХАХЯ-нд хэрэгжүүлж буй бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хөгжлийн

тусламж олгож байгаа түнш орнуудтайгаа хамтран ажиллах асуудлыг зарчмын хувьд эргэн харах, шинэчлэн зохион байгуулах, аль болох цөөн тооны салбарт төвлөрүүлж, үр ашгийг дээшлүүлэх хэмнэлтийн бодлогыг 2000 оны 6 дугаар сараас эхлэн явуулж байна. Энэ бодлогынхоо хүрээнд хамтран ажиллах орнуудын тоог 118-аас 80 болгон цөөлж түнш орнуудын жагсаалтанд үлдсэн орнуудад үзүүлэх тусламжийн хэмжээг 10-30 хувь бууруулж байгаа ажээ.

Хамтын ажиллагааны үндсэн түнш орнуудад нийт 38 орон хамрагдаж байгаа ба тэдгээрээс дор дурдсан орнуудтай үндсэн гурван чиглэлээр хамтран ажиллах юм. Энэ бүлэгт Хятад, Вьетнам, Турк, Өмнөд Африк, Мозамбик, Энэтхэг, Пакистан тэрэг уламжлалт олон жилийн харилцаатай, санхүүгийн хамтын ажиллагааны томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг, олон тооны төсөл хэрэгжиж буй орнууд багтаж байна.

Харин дор дурдсан хамтын ажиллагааны түнш орнуудтай цаашид үндсэн нэг чиглэлээр хамтран ажиллах юм. Энэ бүлэгт Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн дийлэнх орнууд, Тайланд, Бразиль, Иордан зэрэг орноос гадна Монгол Улс багтаж байна.

Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны орнуудынхаа тоог ингэж цөөрүүлснээр хоёр болон олон талын, тэрчлэн Европын Холбооны хөгжлийн бодлогын зохицуулалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилготой нийцэж байгаа гэж Холбооны Засгийн газар үзэж байна. ХБНГУ-ын Засгийн газар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжийнхаа хэмжээг сүүлийн жилүүдэд бууруулахгүй харин ч нэмсээр ирсэн нь хоёр орны хоорондын хөгжлийн бодлогын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаагийн илрэл юм.

ХБНГУ-ын бусад улсуудтай хийсэн Засгийн газар хоорондын хэлэлцээ болон хамтран ажиллаж буй үндсэн чиглэлүүдийг манайхтай харьцуулахад ерөнхийдөө хэлбэрийн хувьд адилхан боловч манай улс байгаль орчныг хамгаалах, түүний өрчны бүс нутгийг хөгжүүлэх чиглэлээр Германы талтай хөтөлбөрийн хэлбэр буюу шинэ хэлбэрээр ажиллахаар болж байгаа цөөхөн орны нэг болж байна.

Сүүлийн үед хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлд хийгдэж буй судалгаа, хамтын ажиллагааны ирээдүйн үр өгөөжийг дээшлүүлэх зорилтуудыг анхаарч судлахад Засгийн газрын хөгжлийн тусламж (татвар төлөгчдийн мөнгө), хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг холбож, цаашид хөгжүүлэх хандлага ажиглагдаж байна. Жишээлбэл: Хөгжлийн хамтын ажиллагаанд шинээр гарч ирсэн хэлбэр болох ППП буюу (Private Public Partnership) хөтөлбөр юм.

Энэ нь хөгжлийн тусламжаар тухайн салбарын эрх зүйн болон санхүүгийн үндсэн суурийг бүрэлдүүлж, түүн дээр нь хувийн хөрөнгө оруулалтыг оруулах замаар үр ашигтай хөгжүүлж, авсан зээлээ будааж төлөх бололцоог хангах зам юм.

Монгол - Германы хөгжлийн хамтын ажиллагааны тухай танилцуулга

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн шинэ замыг бататгаж, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг түргэтгэхэд хандивлагч орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын эдийн засгийн дэмжлэг тусламж онцгой чухал үүрэгтэй байлаа.

Монгол Улс хоёр болон олон талын хамтын ажиллагааны хүрээнд жилд дунджаар 200 сая ам. долларын хөнгөлттэй зээл, тусламжийг авч ашигладаг. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд 13 гаруй улс, олон талт хамтын ажиллагааны хүрээнд 16 орчим олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөгжлийн албан ёсны тусламж авч байна.

Монгол Улс анх 1991 оноос эхлэн ХБНГУ-тай хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд цоо шинээр хамтран ажиллаж эхэлсэн билээ. Монгол, Германы Засгийн газар хоорондын анхны хэлэлцээг 1991 оны 6 дугаар сарын 18-21 өдрүүдэд Улаанбаатар хотноо хийж байсан. Монгол Улс, ХБНГУ-ын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд

ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 379 сая DM-ийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг авсан бөгөөд үүнээс 168 сая DM нь санхүүгийн хамтын ажиллагааны, 132 сая DM нь техникийн хамтын ажиллагааны, 79 сая DM нь хамтын ажиллагааны бусад хэлбэрийн тусламж байна. 1991-ээс 2002 он хүртэл ХБНГУ-ын Засгийн газраас авсан нийт зээл, тусламжийн хэмжээг дараах хүснэгтээр харуулав.

Зээл, тусламжийн хэмжээ

/сая DM/

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998/ 1999	2000/2001	Нийт 1991- 2002
Санхүүгийн хамтын ажиллагаа	15	10	14	17	12	15	15	25+1 ²	20+ 5 ¹	168
Техникийн хамтын ажиллагаа үйлсэн чиглэлээр	9	5	11	11	13	14	15	25+3 ¹	20+ 6 ¹	132
Дүн	24	15	25	28	25	29	30	70	54	300
Техникийн тусламж бусад чиглэлээр										79
Нийт Дүн										379

- 1) 1998 оноос эхлэн 2 жилээр амладаг болсон. Дараагийн Засгийн газар хоорондын хэлэлцээ 2000 оны 11 сард болно.
- 2) Ерөнхийлөгч Роман Херцогийн айлчлалын үеээр нэмж амласан: 17 сая DM, Харилцаа холбоо
- 3) Роман Херцогийн айлчлалын үеээр нэмж амласан: 3 сая DM, Эдийн засгийн эрхийг түлхүү харгалзан эрх зүйн зөвлөлгөө өгөх төсөл
- 4) Засгийн газар хоорондын хэлэлцээнээс гадуур зудын гамшигт 2 сая DM-ийг мөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад 4 сая DM-ийг зориулж олгосон.
- 5) 2001 оны 10 дугаар сард ЭЗХАХЯ-ны газрын дарга Гёрделер Монголд айлчлахдаа 8 сая DM-ийг сэргээгдэх эрчим хүчинд олгосон

Герман-Монгол Засгийн газар хоорондын
санхүүгийн болон техникийн
хамтын ажиллагааны чиглэл:

- Эдийн засаг /олон улсын худалдааны бодлого, жижиг дунд үйлдвэрийг дэмжих/,
- Хууль эрх зүй,
- Мэргэжлийн боловсон хүчнийг хөхүүлэн дэмжих,
- Хөдөө аж ахуй /хөдөө, аж ахуйн үйлдвэрүүдэд зөвөлгөө өгөх, мал эмнэлгийн үйлчилгээг хувьчлах/
- Дэд бүтэц, эрчим хүчний салбарын тогтвортой ажиллагааг хангах /Дарханы дулаан цахилгаан станцыг засварлах, цахилгаан станцын ажиллагсдыг сургах, харилцаа холбоо г.м/
- Байгаль орчныг хамгаалах /Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалтай газар нутгийн хөгжил, ойг зохистой ашиглах, нөөцийг хамгаалах, ойг бий болгох, геологийн албанд дэмжлэг үзүүлэх г.м./

Хоёр орны хөгжлийн хамтын ажиллагааны асуудлаар 1998 он хүртэл жил бүр Засгийн газар хоорондын хэлэлцээний урьдчилсан зөвлөлдөөн, хэлэлцээг хийж байсан бол 1998 оноос эхлэн 2 жилд нэг удаа хийж байхаар тохиролцож, сүүлийн хэлэлцээг 2000 оны 11 дүгээр сард Бонн хотноо хийсэн болно. Энэ нь хоёр орны хоорондын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн тоо ихэссэн, хэрэгжиж буй төслүүдийг нэгтгэж хөтөлбөрийн хэлбэрт оруулах эхлэлийг хийсэнтэй холбоотой юм. Засгийн газар хоорондын 2000 оны 11 дүгээр сарын хэлэлцээгээр хоёр тал сүүлийн 10 жилд монгол, германы хамтын ажиллагааны гол гол салбарт хэрэгжиж буй төслүүдийг хамтран шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөхөөр тохиролцсон юм. Өнгөрсөн хугацаанд нийт 20-иод төрлийн төсөл хэрэгжсэн, одоо 17 төсөл хэрэгжих шатандаа байна. 2000 оны 3 дугаар сард ХБНГУ-ын ЭЗХАХЯ-наас Монголд илгээсэн Германы шинжээчийн ажлын хэсэг монголын

шинжээчидтэй хамтран 1991 оноос хойшхи зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн байдалд шалгалт хийж, дүгнэлт гаргасан.

Шалгалтын дүгнэлтэд үндэслэн ХБНГУ-ын Засгийн газар манай талтай үндсэн 2 чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. Энэ нь Германы хөгжлийн хамтын ажиллагааны бодлогын шинэ үзэл баримтлалтай шууд холбоотой.

2002 оноос эхлэн хоёр орны Засгийн газар хоорондын санхүүгийн болон техникийн хамтын ажиллагааг:

- Эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн хөгжил
- Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зөв зохистой ашиглах /сэргээгдэх эрчим хүч/ гэсэн үндсэн хоёр чиглэлээр хөгжүүлэх юм.

Мөн 2000 оны 11 дүгээр сарын хэлэлцээний үед одоо хэрэгжиж байгаа дийлэнх төслүүдийг үргэлжлүүлэхээр тохиролцож, хөрөнгө нэмсэнээр 2002/2003 он хүртэл хөдөө аж ахуйн зарим төслөөс бусад бүх төслүүд хэрэгжиж дуусах болно. Нөгөө талаар одоо хэрэгжиж буй бүх төслүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусгана гэдгээ Германы тал албан ёсоор мэдэгдсэн.

2002/2003 оны Засгийн газрын хоорондын хэлэлцээг энэ 9 дүгээр сард хийхээр тохиролцоод байна. Албан ёсны дээрх хөгжлийн хамтын ажиллагааны зэрэгцээ улс төрийн сангууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хооронд олон чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна.